

АУДИТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

1. Аудитын нэр

“Авто замын сангийн 2017 оны төлөвлөлт, бүрдүүлэлт, зарцуулалтын үр ашиг”

2. Аудитын код ҮАГ-БНАТАГ-/2018/-02-ГА

3. Аудит хийх үндэслэл, бүрэн эрх

Баянхонгор аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2017 оны 07 дугаар сарын 28-ны өдрийн 1а/398 тоот албан бичгээр ирүүлсэн аудит хийлгэх захиалгыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 19.1 дүгээр зүйлд заасан Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийнэ.

4. Аудитын зорилт

Авто замын сангийн төлөвлөлт, бүрдүүлэлт, зарцуулалтын үр ашигт аудит хийж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдэнэ.

Аудитыг дараах дэд зорилтын хүрээнд хийнэ. Үүнд:

- Авто замын санд төвлөрөх хөрөнгийг бодитой тооцож төлөвлөн, бүрэн бүрдүүлсэн эсэх
- Авто замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг холбогдох хууль, журмын дагуу баталж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулсан эсэх
- Төсөл, арга хэмжээ үр дүнтэй хэрэгжсэн эсэх

5. Аудитын хамрах хүрээ

Аудитад авто замын сангийн хөрөнгөөр 2017 онд батлагдан хэрэгжсэн төсөл арга хэмжээг хамруулан аймгийн ЗДТГ-ын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс, Санхүү, төрийн сангийн хэлтэс, Татварын хэлтэс, Орон нутгийн өмчийн газар, Баянхонгор аймгийн Авто тээврийн төв зэрэг байгууллагуудаас шаардлагатай санхүүгийн баримт, ИТХ-ын тогтоол, мэдээ, тайлан, судалгаа бусад материалд тулгуурлан гүйцэтгэлийн аудитыг хийнэ.

6. Үндсэн мэдээлэл:

Баянхонгор аймагт 2017 онд АТӨЯХАТ-аар 374,2 сая, авто зам ашигласны хураамжаас 116,1 сая, урьд оны үлдэгдлээс 61,0 сая, нийт 551,3 сая төгрөгийн орлого бүрдүүлэхээр төлөвлөж, хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтыг аймгийн ИТХ-аар анх 16 төсөл арга хэмжээнд 345,6 сая төгрөгийг баталж, тайлант хугацаанд 3 удаа тодотгож, нийт 25 төсөл арга хэмжээнд 551,3 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийхээр төсвийг баталж, тайлант онд АТӨЯХАТ-аар

399,6 сая, авто зам ашигласны хураамжийн орлогоор 117,5 сая төгрөг, нийт 517,1 сая төгрөгийн орлого бүрдүүлж, аймгийн Авто замын санд 380,0 сая төгрөгийг төвлөрүүлж, нийт 25 төсөл арга хэмжээний гүйцэтгэлд 475,3 сая төгрөгийн санхүүжилт олгожээ.

7.Эрсдэлийн үнэлгээ

Урьдчилсан судалгааны явцад хийсэн дүн шинжилгээ, харилцан ярилцлагад үндэслэн ерөнхий эрсдэлийг "дунд" гэж үнэлэв (*Эрсдэлийн үнэлгээг хавсралт № 1-ээс үзнэ үү.*)

8. Аудитын арга зүй

Аудитыг гүйцэтгэхэд Төрийн хяналт, шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын удирдамжийн хүрээнд аймгийн ЗДТГ, Орон нутгийн өмчийн газар, Татварын хэлтэс, МХГ, ГХБХБГ-ын холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийж. асуулга лавлагаа, тодруулга авч, байгууллагын худалдан авалт хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, бусад шаардлагатай баримт материалд тулгуурлан дүн шинжилгээ хийж, аудитын хөтөлбөр, горим. асуудлын шинжилгээ, шалгах хуудасны дагуу нотлох зүйл цуглуулж. дүн, дүгнэлт, зөвлөмж боловсруулна.

9.Аудитад ашиглах шалгуур үзүүлэлтүүд:

Аудитад дараах хууль. эрх зүйн актыг шалгуур үзүүлэлт болгон ашиглана Үүнд:

- Төрийн аудитын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Төсвийн тогтвортой байдлын тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ, худалдан авах тухай хууль
- Барилгын тухай хууль
- Автозамын тухай хууль
- Засгийн газрын 1998 оны 149 дүгээр тогтоолоор баталсан “Авто замын санг төлөвлөх, түүнд хөрөнгө төвлөрүүлэх, захиран зарцуулах журам”
- Сангийн сайдын 2012 оны 264 дүгээр тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам.
- Сангийн сайд, Дэд бүтцийн хөгжлийн сайдын 2000 оны 47/81 дүгээр хамтарсан тушаалаар баталсан “Орон нутгийн замын сангийн сангийн хөрөнгөөр санхүүжигдэх авто зам, замын байгууламжийн ажлыг гүйцэтгэх, хянаж, санхүүжүүлэх журам”
- Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналтын журам”
- Холбогдох бусад эрхийн актууд

10.Аудит хийх хугацаа

Аудитыг 2017 оны 04 дүгээр сарын 01-ны өдөр эхэлж, тайланг 2017 оны 4 дүгээр сарын 20-нд дуусгаж, удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, аймгийн ИТХ-д хүргүүлнэ.

11.Аудит хийх багийн бүрэлдэхүүн

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат удирдаж, аудитын менежер Д.Цэцэгмаа үе шатны чанарын хяналтыг хэрэгжүүлж, аудитор П.Мөнх-Эрдэнэ, Б.Нарангэрэл нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэнэ.

12.Аудитад шаардагдах хөрөнгө, нөөц

а. Боловсон хүчин: 2*15 өдөр =30 хүн/өдөр


б. Санхүүгийн нөөц: Цалин 2039.1 мянган төгрөг, шатахуун 40.0 мянган төгрөг, бичиг хэргийн зардал 54,0, томилолтын зардал 18.0, нийт 2151.1 мянган төгрөг.

в. Техник хэрэгсэл: Зөөврийн компьютер, фото аппарат болон бусад техник хэрэгсэл.

Аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийг:

Хянасан: Аудитын менежер

Боловсруулсан: Аудитор



Д.Цэцэгмаа

П.Мөнх-Эрдэнэ

Б.Нарангэрэл

2018 оны 04 дүгээр сарын 05-ны өдөр

АУДИТЫН ЭРСДЭЛЛҮҮД БА ҮНЭЛГЭЭ

Аудитын нэр: "Авто замын сангийн 2017 оны төлөвлөлт, бүрдүүлэлт, зарцуулалтын үр ашиг"

Аудитын код: УАГ-БНАТАГ-/2018/02-ГА

№	Эрсдэл	Магадлал	Үр дагавар	Үнэлгээ
1	Авто замын санд төвлөрөх хөрөнгийг бодитой төлөвлөсөн үү?	Их	Их	Их
2	Авто замын санд төвлөрөх орлогыг бүрэн бүрдүүлсэн үү?	Дунд	Их	Их
3	Аймгийн эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд хөрөнгө оруулалтын ТАХ нь тусгагдсан уу?	Дунд	Их	Их
4	Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний ТЭЗҮ-ийг урьдчилан төлөвлөсөн үү?	Дунд	их	их
5	Гүйцэтгэчийг сонгон шалгаруулах ажиллагаа холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулагдсан уу?	Дунд	Дунд	Дунд
6	Гүйцэтгэгч байгууллага гэрээний үүргээ хугацаанд нь бүрэн биелүүлсэн үү?	Дунд	Дунд	Дунд
7	Гүйцэтгэгч байгууллагад гэрээний дагуу санхүүжилтийг бүрэн олгосон уу?	Дунд	Дунд	Дунд
8	Захиалагч байгууллага гэрээний хэрэгжилтэд тавих хяналтыг үр нөлөөтэй хэрэгжүүлсэн үү?	Дунд	Дунд	Дунд
9	Хөрөнгө оруулалтын ТАХ үр дүнтэй хэрэгжсэн үү?	Дунд	Дунд	Дунд
10	Хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд бүрэн тусгасан уу?	Бага	Бага	Бага

"Их" гэж үнэлэгдсэн

4

"Дунд" гэж үнэлэгдсэн

5

"Бага" гэж үнэлэгдсэн

1

Эрсдэлийн ерөнхий үнэлгээ

Дунд

Гүйцэтгэлийн аудитын арга зүй

Аудитын нэр: "Авто замын сангийн 2017 оны төлөвлөлт, бүрдүүлэлт, зарцуулалтын үр ашиг"

Аудитын код: УАГ-БНАТАГ-/2018/02-ГА

1 дэхь түвшин	2 дахь түвшин	3 дахь түвшин	Шалгуур үзүүлэлт	Мэдээллийг цуглуулах, асуудлыг шалгах арга зүй
7 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүн, үр ашиг	1. Авто замын санд төвлөрөх хөрөнгийг бодитой тооцож төлөвлөн, бүрэн бүрдүүлсэн эсэх	1.1. Авто замын санд төвлөрөх хөрөнгийг бодитой тооцож, төлөвлөсөн үү?	1.Төсвийн тухай хууль 2.Төрийн аудитын тухай хууль 3.Барилгын тухай хууль 4. Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль 5.ТБОНӨХБАУХАТ хууль 6.Сангийн сайдын 2012 оны 264-р тоот тушаалаар батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам" 7. Сангийн сайдын 2016 оны 415-р тушаалаар батлагдсан "Төсвийн хөрөнгө оруулалтын журам" 8.Засгийн газрын 1998 оны 149 дүгээр тогтоолоор баталсан "Авто замын санг төлөвлөх, түүнд хөрөнгө төвлөрүүлэх, захиран зарцуулах журам" 9.Авто замын тухай хууль	Аймгийн ИТХ-ын тогтоол, холбогдох баримт материалтай танилцах, судалгаа хийх, тайлбар мэдээ гаргуулах, ярилцлага хийх, аудитын бусад горим арга зүйг ашиглана.
		1.2. Авто замын санд төвлөрөх хөрөнгийг хууль, журмын дагуу бүрэн бүрдүүлсэн үү?	1. Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль 2. Автотээвэр болон өөрөө явагч хэрэгсэлийн албан татварын тухай хууль 3. Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар батлагдсан "Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналын журам 4.Засгийн газрын 1998 оны 149 дүгээр тогтоолоор баталсан "Авто замын санг төлөвлөх, түүнд хөрөнгө төвлөрүүлэх, захиран зарцуулах журам"	Холбогдох баримт материалтай танилцах, судалгаа хийх, тайлбар мэдээ гаргуулах, аудитын бусад горим арга зүйг ашиглана.
	2.Авто замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг холбогдох хууль, журмын дагуу баталж, гүйцэтгэчийг сонгон шалгаруулах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулсан эсэх	2.1. ТАХ-г урт болон дунд хугацааны хөтөлбөрт үндэслэж төлөвлөсөн үү?	1. Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль 2. Баянхонгор аймгийн Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр 3. Аймгийн эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэл 4. Баянхонгор аймгийг 2016-2025 онд хөгжүүлэх хэтийн зорилт	Аймгийн эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, Засаг даргын мөрийн хөтөлбөр, түүний хэрэгжилттэй танилцах, холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх.
		2.2. Авто замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний ТЭЗҮ-ийг боловсруулж, холбогдох хууль, журмын дагуу баталсан уу?	1. Авто замын тухай хууль 2. Төсвийн тухай хууль /29.4/ 3. Сангийн сайдын 2012 оны 264-р тоот тушаалаар батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам" 4. Сангийн сайдын 2016 оны 415-р тушаалаар батлагдсан "Төсвийн хөрөнгө оруулалтын журам" 5.Засгийн газрын 1998 оны 149 дүгээр тогтоолоор баталсан "Авто замын санг төлөвлөх, түүнд хөрөнгө төвлөрүүлэх, захиран зарцуулах журам"	Аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ-ийн холбогдох албан тушаалтнаас тодруулга, тооцоо судалгааг гаргуулах
		2.3. Хөрөнгө оруулалтын ТАХ-г худалдан авах ажиллагааны хууль, журмын дагуу зохион байгуулсан үү?	1.Сангийн сайдын 2012 оны 264-р тоот тушаалаар батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам" 2. Сангийн сайдын 2016 оны 415-р тушаалаар батлагдсан "Төсвийн хөрөнгө оруулалтын журам"	Аймгийн Худалдан авах ажиллагааны албанаас ирүүлсэн гүйцэтгэчийг сонгон шалгаруулах тендерийн баримт бичигтэй танилцах, ярилцлага хийх, тайлбар гаргуулах
	3.1. Гүйцэтгэгч байгууллага гэрээний үүргээ тавигдах шаардлагын дагуу хугацаанд нь бүрэн биелүүлсэн үү?	1. Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль 2. Гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ 3.Сангийн сайдын 2012 оны 264-р тоот тушаалаар батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам" 4. Сангийн сайдын 2016 оны 415-р тушаалаар батлагдсан "Төсвийн хөрөнгө оруулалтын журам" 5.Засгийн газрын 1998 оны 149 дүгээр тогтоолоор баталсан "Авто замын санг төлөвлөх, түүнд хөрөнгө төвлөрүүлэх, захиран зарцуулах журам"	Гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний хэрэгжилтийг ажлын гүйцэтгэлтэй тулган шалгах	

1 дэхь түвшин	2 дахь түвшин	3 дахь түвшин	Шалгуур үзүүлэлт	Мэдээллийг цуглуулах, асуудлыг шалгах арга зүй
"Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2014"	3. Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ үр дүнтэй, үр ашигтай хэрэгжсэн эсэх	3.2. Гүйцэтгэгч байгууллагад гэрээний дагуу санхүүжилтийг бүрэн олгосон уу?	1. Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль 2. Гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ 3. Сангийн сайдын 2012 оны 264-р тоот тушаалаар батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам" 4. Сангийн сайдын 2016 оны 415-р тушаалаар батлагдсан "Төсвийн хөрөнгө оруулалтын журам" 5. Засгийн газрын 1998 оны 149 дүгээр тогтоолоор баталсан "Авто замын санг төлөвлөх, түүнд хөрөнгө төвлөрүүлэх, захиран зарцуулах журам" 6. Авто замын тухай хууль	Гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний хэрэгжилтийг ажлын гүйцэтгэлтэй тулган шалгах
		3.3. Захиалагч байгууллага гэрээний хэрэгжилтэд тавих хяналтыг үр нөлөөтэй хэрэгжүүлсэн үү?	1. Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль 2. Гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ 3. Сангийн сайдын 2012 оны 264-р тоот тушаалаар батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам" 4. Сангийн сайдын 2016 оны 415-р тушаалаар батлагдсан "Төсвийн хөрөнгө оруулалтын журам" 5. Засгийн газрын 1998 оны 149 дүгээр тогтоолоор баталсан "Авто замын санг төлөвлөх, түүнд хөрөнгө төвлөрүүлэх, захиран зарцуулах журам" 6. Авто замын тухай хууль	Ажил гүйцэтгэх гэрээнд тусгагдсан ажлын хэрэгжилтийг шалгах, ажил хүлээлцсэн акт, холбогдох бусад баримттай танилцах, мэргэжилтнүүдээс тайлбар гаргуулах, ярилцлага хийх
		3.4. Хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд бүрэн тусгасан уу?	1. Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль 2. Гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ 3. Сангийн сайдын 2012 оны 264-р тоот тушаалаар батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам" 4. Сангийн сайдын 2016 оны 415-р тушаалаар батлагдсан "Төсвийн хөрөнгө оруулалтын журам" 5. Засгийн газрын 1998 оны 149 дүгээр тогтоолоор баталсан "Авто замын санг төлөвлөх, түүнд хөрөнгө төвлөрүүлэх, захиран зарцуулах журам"	Ашиглагч байгууллагуудаас орлогын баримтыг авч тулгах

Бэлтгэсэн: Аудитор  П.Мөнх-Эрдэнэ

Аудитор  Б.Нарангэрэл

АСУУДЛЫН ШИНЖИЛГЭЭ

" Авто замын сангийн 2017 оны төлөвлөлт, бүрдүүлэлт, зарцуулалтын үр ашиг"

1.Авто замын санд төвлөрөх хөрөнгийг бодитой тооцож төлөвлөн, бүрэн бүрдүүлсэн эсэх

2.Авто замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг холбогдох хууль, журмын дагуу баталж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулсан эсэх

3.Төсөл, арга хэмжээ үр дүнтэй хэрэгжсэн эсэх

1.1. Авто замын санд төвлөрөх хөрөнгийг бодитой тооцож, төлөвлөсөн үү?

1.2. Авто замын санд төвлөрөх хөрөнгийг хууль, журмын дагуу бүрэн бүрдүүлсэн үү?

2.1. ТАХ-г урт болон дунд хугацааны хөтөлбөрт үндэслэж төлөвлөсөн үү?

2.2. Авто замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний ТЭЗҮ-ийг боловсруулж, холбогдох хууль, журмын дагуу баталсан уу?

2.3. Хөрөнгө оруулалтын ТАХ-г худалдан авах ажиллагааны хууль, журмын дагуу зохион байгуулсан уу?

3.1. Гүйцэтгэгч байгууллага гэрээний үүргээ бүрэн биелүүлсэн үү?

3.2. Гүйцэтгэгч байгууллагад гэрээний дагуу санхүүжилтийг бүрэн олгосон уу?

3.3. Захиалагч байгууллага гэрээний хэрэгжилтэд тавих хяналтыг үр нөлөөтэй хэрэгжүүлсэн үү?

3.4. Хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд бүрэн тусгасан уу?

3.5. Өмнөх аудитаар өгөгдсөн зөвлөмжийн хэрэгжилт

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ХӨТӨЛБӨР

Аудитын код: УАГ-БНАТАГ-/2018/-02-ГА

Аудитын нэр: "Авто замын сангийн 2017 оны төлөвлөлт, бүрдүүлэлт, зарцуулалтын үр ашиг"

№	Аудитын үе шат бүрд хэрэгжүүлэх арга хэмжээ	Нийт өдөр	4 сар																								8 сар	Хариуцах ажилтан
			2	3	4	5	6	9	10	11	12	13	16	17	18	19	20	23	24	25	26	27	25					
1. Аудитын төлөвлөлтийн өмнөх үе шат																												
1.1	Аймгийн СТСХ-ээс татварын орлогын судалгаа, ХОХБТХ-ээс замын сангаас хэрэгжүүлсэн арга хэмжээний судалгаа, баримт материал, аймгийн ИТХ-ын тогтоол авах, Татварын хэлтэс болон Авто тээврийн төвөөс тээврийн хэрэгслийн тоо бүртгэлийн судалгаа	3																										Аудитор П.Мөнх-Эрдэнэ, Б.Нарангэрэл
1.1	Өмнөх онуудад хийгдсэн гүйцэтгэлийн аудитын материалтай танилцах	1																										Аудитор П.Мөнх-Эрдэнэ, Б.Нарангэрэл
2. Аудитын ажлыг эхлүүлэх үе шат																												
2.1	Аудитын арга зүй, эрсдэл, асуудлын шинжилгээг тодорхойлж, үр өгөөжийн тооцоо гарган, аудитын төлөвлөгөө, хөтөлбөр боловсруулж батлуулах	1																										Аудитор П.Мөнх-Эрдэнэ, Б.Нарангэрэл
2.2	Аудитын нээлтийг хийж, холбогдох байгууллагын удирдлага, албан тушаалтнуудад гүйцэтгэлийн аудитын талаар мэдээлэл солилцож, аудитын багийг танилцуулах	1																										Тэргүүлэх аудитор Б.Мөнхбат Аудитын менежер Д. Цэцэгмаа, Аудитор П.Мөнх-Эрдэнэ, Б.Нарангэрэл
3. Аудитын гүйцэтгэлийн үе шат: Гүйцэтгэлийн аудитын төлөвлөгөөний дагуу 4-т дурдсан зорилтуудын хүрээнд холбогдох мэдээлэл, нотлох зүйл цуглуулах, баримтжуулах, нотлох зүйлийг нягтлах.Үүнд:																												
3.1	Авто замын санд төвлөрөх хөрөнгийг бодитой тооцож төлөвлөн, бүрэн бүрдүүлсэн эсэх	5																										Аудитор Б.Нарангэрэл
3.2	Авто замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг холбогдох хууль, журмын дагуу баталж, гүйцэтгэчийг сонгон шалгаруулах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулсан эсэх		Аудитор П.Мөнх-Эрдэнэ																									
3.3	Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ үр дүнтэй хэрэгжсэн эсэх		Аудитор П.Мөнх-Эрдэнэ, Б.Нарангэрэл																									
4. Аудитын тайлагналын үе шат																												
4.1	Аудитаар олж илрүүлсэн зүйлсийг нэгтгэж шинжилгээ хийнэ.	2																										Аудитор П.Мөнх-Эрдэнэ, Б.Нарангэрэл
4.2	Зорилт тус бүрээр аудитын үр дүнг тодорхойлно																											
4.3	Гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөл бэлтгэнэ																											
4.4	Аудитын дүн, дүгнэлт, зөвлөмжийн төслийг аудитын багаар хэлэлцүүлэх																											

№	Аудитын үе шат бүрд хэрэгжүүлэх арга хэмжээ	Нийт өдөр	4 сар																				8 сар	Хариуцах ажилтан		
			2	3	4	5	6	9	10	11	12	13	16	17	18	19	20	23	24	25	26	27	25			
4.5	Тайланг бичих, зөвлөмж бэлтгэж аудитын менежерээр хянуулах.	1																							Аудитор П.Мөнх-Эрдэнэ, Б.Нарангэрэл	
4.6	Тайланг засварлаж, Тэргүүлэх аудитораар хянуулах.																									
4.7	Аудитын тайланг холбогдох байгууллагад танилцуулж, удирдлагаас санал, тайлбарыг албан тоотгоор авна.	1																								
4.8	Аудитын тайланг Аудитын удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн батлуулж хүргүүлэх	1																								
5. Тайлагналын дараахь үе шат																										
5.1	Аудитын багийн ажлыг дүгнэж, үнэлгээ өгөх																									Тэргүүлэх аудитор Б.Мөнхбат
5.2	Ажлын баримтыг архивт өгөх																									Аудитор Б.Нарангэрэл
5.3	Сонинд хэвлэлийн материал бэлтгэх																									Аудитор П.Мөнх-Эрдэнэ
6. Аудитын мөрөөр авах үйл ажиллагаа																										
6.1	Өгсөн зөвлөмжүүдийг бүртгэж, хэрэгжилтэнд хяналт тавих																									Аудитор П.Мөнх-Эрдэнэ, Б.Нарангэрэл
6.2	Зөвлөмжийн хэрэгжилтийг холбогдох байгууллагуудаас гаргуулан авч дүн шинжилгээ хийх																									Аудитор П.Мөнх-Эрдэнэ, Б.Нарангэрэл
Аудитад зарцуулах нийт өдөр		15																								

Хөтөлбөрийг боловсруулсан: Аудитор  П.Мөнх-Эрдэнэ

Аудитор  Б.Нарангэрэл